



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/16/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Энхжаргал

Утас: 99434344

Цахим хаяг: Enkhjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.03.22 № 1/119
танай 2024.03.04-ны № 1/53 -т

**ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
УЦЭРЭНТОГТОХ ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй ажлууд санхүүжүүлсэн, зарцуулалт нь анхан шатны баримтаар нотлогдоогүй зардлыг хувь хүний дансанд шилжүүлсэн, хийж хэрэгжүүлсэн ажлуудын анхан шатны баримт дутуу актаар хүлээж аваагүй, Төрийн хэмнэлтийн хууль, төсвийн тухай хууль болон ОНХС-н журам зөрчсөн хөшөө дурсгал, баяр наадам, баримтат киноны зардлуудыг санхүүжүүлсэн, малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлсэн ажлууд анхан шатны баримтгүй, ямар ажил хийсэн нь тодорхойгүй, жолоочийн тооцоо бодож замын хуудас баталгаажуулаагүй, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй зэрэг 225.0 сая төгрөгийн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 18 дугаар зүйлийн 18.1.Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.3.2 "ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх", Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.3 "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал", Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.4. "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт,

хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ", "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 "хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Иж бүрэн байх", Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсөвт байгууллага, 2 тусгай сан, сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Эрдэнэбүрэн сумын 2023 оны төсвийн орлогыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор татвар, татварын бус орлогыг 367,510.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 428,959.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 61,449.0 мянган төгрөгөөр буюу 16.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Сумын ИТХ-н Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 14-ний 07 дугаар тогтоолоор 4091566 регистрийн дугаартай "Хар ус" ААТҮГ-г байгуулж, ИТХ-н 2022 оны 12 дугаар сарын 14-ний 8/08 дугаар тогтоолоор татан буулгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны 18/03 тоот тогтоолоор "сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2023 оны хэрэгжилтийг 100 хувь буюу "хангалттай" гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	323,757.6	432,792.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	73,457.9	128,148.7
33	АВЛАГА	187,708.3	197,805.6
34	УРЬДЧИЛГАА	3,500.0	49,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	59,091.4	57,838.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,257,014.6	2,487,911.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,257,014.6	2,487,911.4
39200	Биет хөрөнгө	2,232,039.7	2,463,405.2
39300	Биет бус хөрөнгө	24,975.0	24,506.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,580,772.3	2,920,703.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,532.3	219.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,532.3	219.6
41300	Өглөг	18,532.3	219.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,562,240.0	2,920,484.1
51	Засгийн газрын хувь оролцоо	2,562,240.0	2,920,484.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	609,081.2	609,081.2
51200	Хуримтлагдсан үр дүн	1,724,077.4	2,082,321.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	229,081.4	229,081.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,580,772.3	2,920,703.7

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,828,892.9	2,090,181.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	397,970.6	427,000.1
110	Орлогын албан татвар	155,848.7	175,055.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	155,848.7	194,754.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-19,698.8
113	Хөрөнгийн албан татвар	50,099.0	58,606.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	192,023.0	193,338.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	507,609.7	386,380.9
120	Нийтлэг татварын бус орлого	507,609.7	386,380.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,923,312.6	1,276,800.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,578,421.0	1,732,653.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,578,421.0	1,732,653.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,600,943.4	1,696,984.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,327.7	477,371.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,858.7	59,040.2

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	409,582.0	147,583.1
2104	Хангамж, бараа материалын зардал	329,317.1	325,491.1
2105	Нормативт зардал	375.0	182.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,018.7	2,844.3
2107	Томилолт, зочны зардал	2,691.7	6,107.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,202.8	409,642.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	446,569.7	268,722.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	977,477.6	35,669.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	250,471.9	357,528.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,244,803.4	357,528.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,358,426.4	1,735,634.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	397,970.6	427,000.1
110	Орлогын албан татвар	155,848.7	175,055.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	155,848.7	194,754.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-19,698.8
113	Хөрөнгийн албан татвар	50,099.0	58,606.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	192,023.0	193,338.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,697.6	40,341.6
1181	Газрын төлбөр	3,079.2	1,282.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	180,246.2	151,714.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,143.2	31,833.5
120	Нийтлэг татварын бус орлого	37,143.2	31,833.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,923,312.6	1,276,800.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,144,501.5	1,152,633.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,144,501.5	1,152,633.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,159,314.3	1,116,964.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,350.3	472,949.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,227.8	63,261.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	409,961.8	147,583.1
2104	Хангамж, бараа материалын зардал	15,219.7	26,276.8
2105	Нормативт зардал	318.3	502.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,533.9	1,954.3
2107	Томилолт, зочны зардал	2,691.7	6,107.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,876.4	336,572.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	311,134.4	61,757.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	985,187.2	35,669.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	213,924.9	583,001.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	290,711.3	493,310.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	290,711.3	493,310.3
2200	Дотоод эх үүсвэрээр	290,711.3	493,310.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-290,711.3	-493,310.3

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-40,000.0	-35,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,000.0	35,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-116,786.4	54,690.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	190,244.3	73,457.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	73,457.9	128,148.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Дахин үнэлгэ эний нөөц	Хуримтлагдсан дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,961,661.7	1,711,630.7	1,150,581.1	4,823,873.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,352,580.7)	(1,482,549.3)	2,818,299.7	-16,830.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	609,081.2	229,081.4	3,968,880.8	4,807,043.4
9	Тайлант үеийн үр дүн			-2,244,803.4	-2,244,803.4
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	609,081.2	229,081.4	1,724,077.4	2,562,240.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	609,081.2	229,081.4	1,724,077.4	2,562,240.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			716.2	716.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	609,081.2	229,081.4	1,724,793.6	2,562,956.2
19	Тайлант үеийн үр дүн			357,527.9	357,527.9
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	609,081.2	229,081.4	2,082,321.5	2,920,484.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,526,009.4	1,444,229.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,154,381.6	1,117,153.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,152,369.6	1,115,141.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,090.0	472,949.1
210101	Үндсэн цалин	279,559.5	250,068.4
210102	Нэмэгдэл	145,391.0	141,741.2
210104	Урамшуулал	24,525.3	24,525.3
210105	Гэрээт ажлын хөлс	56,614.2	56,614.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,261.1	63,261.1

210201	Тэтгэврийн даатгал	43,017.7	43,017.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,060.8	5,060.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,867.4	3,867.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,193.4	1,193.4
210205	Эрүүл мэндийн даатгал	10,121.8	10,121.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,655.6	435,101.4
210301	Гэрэл, цахилгаан	20,401.6	20,401.6
210302	Түлш, халаалт	415,010.4	411,456.2
210303	Цэвэр, бохир ус	3,243.6	3,243.6
2104	Хангамж, бараа материалын зардал	20,200.9	20,200.9
210401	Бичиг хэрэг	2,497.4	2,497.4
210402	Тээвэр, шатахуун	14,268.4	14,268.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,435.1	3,435.1
2105	Нормативт зардал	502.6	502.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	502.6	502.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,582.4	9,582.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.6	280.6
210604	Урсгал засвар	9,301.8	9,301.8
2107	Томилолт, зочны зардал	6,196.6	6,107.2
210702	Дотоод албан томилолт	6,196.6	6,107.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,327.8	14,884.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,647.9	13,647.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	369.4	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	145.0	145.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225.0	225.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30.0	30.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	787.5	787.5
210807	Газрын төлбөр	123.0	49.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,552.6	92,552.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,277.0	91,277.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,275.6	1,275.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,012.0	2,012.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,012.0	2,012.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,012.0	2,012.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	292,075.7	292,075.7
220001	Барилга байгууламж	30,000.0	30,000.0
221001	Их засвар	20,000.0	20,000.0
222001	Тоног төхөөрөмж	135,856.5	135,856.5
223001	Бусад хөрөнгө	106,219.2	106,219.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	79,552.1	35,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	79,552.1	35,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,526,009.4	1,439,034.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,445,852.3	1,408,624.5

320001	Орон нутгийн төсвөөс	1,192,403.2	1,155,175.4
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	253,449.1	253,449.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	80,157.1	30,409.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.0	605.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000.0	29,804.5
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	39,552.1	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	39,552.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	34,356.6
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	62	62
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30	30
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	7	7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30	30
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650010	Гэрээт ажилтан	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	236,479.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,737.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,080.7
2104	Хангамж, бараа материалын зардал	6,075.9
210402	Тээвэр, шатахуун	6,075.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,307.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,307.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,697.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,697.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,657.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,657.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,657.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	149,742.2
2200	Дотоод эх үүсвэрээр	149,742.2
221001	Их засвар	52,942.4
222001	Тоног төхөөрөмж	96,799.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	236,479.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,479.9
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000.0

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	232,641.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,798.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,040.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,000.0 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил илэрснээс аудитын явцад 11,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулав. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд худалдаж авсан багийн дарга нарын 5 ширхэг мотоциклийг дансанд бүртгээгүй

Аудитаар нийт 296,022.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 4,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 89,013.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 203,008.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой төлбөрийн акт

- ✓ Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажил "Чулуун арслан" хөшөө дурсгалыг 4.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.6 "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1-д "хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах"-г зөрчсөн тул акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой

Малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлсэн "Өвс тэжээл", "Тохижилт", "Малын эрүүл мэнд хамгаалах", "Малын сэг зэм устгах", "Намарзан багийн халдваржуулалд" зэрэг ажлуудын анхан шатны баримт, ажлын тайлан, хүлээн авсан акт байхгүй, юу хийсэн нь тодорхойгүй 38.2 сая төгрөгийн зардал гарсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", ОНХС-н журмын 4.3.2-т "ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх"-г зөрчсөн байна.

3.2.2 "Өөлд түмний наран хийморь" баримтат кино бүтээх, "Ургийн бичигтэй өөлд түмний удам соёлыг сурталчлах өдөрлөг, баяр наадам, баримтат кино санхүүжүүлсэн, "Тохижилт" буюу урсгал зардал, жишиг хашаа санхүүжүүлэхэд нийт 50,856.5 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.3-д "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал", Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.4-д "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ", 4.3.2-т "ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт,

¹ Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" -г тус тус зөрчиж байна

3.3 Зөвлөмж

3.3.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой

Илрүүлэлт: Иргэдийн саналаар дэмжигдээгүй "Спорт заалны чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж авах", "Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат", "Ахмадын өргөөний тохижилт, тоног төхөөрөмж", "Адапт төсөл хэрэгжүүлэх", "Ногооны зоорь, махан зоорь, нядалгааны цэгийн нэгдсэн хашаа ", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр ", "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр", "Гамшгийн бэлэн байдлыг хангах хөтөлбөр", "замын транс чөлөөлөх ажлыг Тэнгэрлиг ойрд ХХК-р гүйцэтгүүлсэн ажил", "Шураг баг баригдсан мал угаах ванн", " Хогийн менежмент, ажлын хөлс, ЗД-н дэд хөтөлбөр, Ич гүрэнд тоног төхөөрөмж, материалын үнэ" зэрэг ажлууд нь хүлээн авсан акт, ажлын тайлангүй, анхан шатны баримт бүрдүүлээгүй 118.2 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 4.3.2-т "ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хийгдсэн ажлуудыг акт үйлдэн хүлээн авч, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, ОНХС-н хөрөнгийг журамд заасны дагуу зарцуулах

3.3.2 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Тайлан дээр байгууллагаас авах авлагаар бүртгэгдсэн он дамжсан зээлийн үлдэгдэл нь 13.8 сая төгрөгийн эзэн холбогдогч байхгүй, барьцаалбар үүсгээгүй, зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй, 2011-2019 онуудад олгогдсон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулаагүй зөрчил байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан журмын 3.4.3-д "төслийг хэрэгжүүлэх этгээдтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих", 3.4.4-д "энэ журмын 3.4.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах бөгөөд үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх", Хошоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 6.10.7-д "барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдсэн тухай баримтыг хавсаргана" нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зээлийн мэдээллийн санд бүртгээгүй 13.8 сая төгрөгийн зээлийн эзэн холбогдогчийг нь тогтоон зээлийн мэдээллийн санд бүртгүүлж барагдуулах, хугацаа хэтэрсэн 4 иргэнтэй холбоотой 26.0 сая төгрөгийн зээлийг шүүхэд шилжүүлэх, шүүхийн шийдвэр гарсан боловч барагдаагүй 10 иргэний зээлийг барагдуулах ажлыг ШШГГ-тай хамтран зохион байршуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
	ДҮН	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Орон нутгийн хөгжлийн сан	Иргэдийн саналаар дэмжигдээгүй "Спорт заалны чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж авах", "Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат", "Ахмадын өргөөний тохижилт, тоног төхөөрөмж", "Адапт төсөл хэрэгжүүлэх", "Ногооны зоорь, махан зоорь, нядалгааны цэгийн нэгдсэн хашаа", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр", "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр", "Гамшгийн бэлэн байдлыг хангах хөтөлбөр", "замын транс чөлөөлөх ажил", "Шураг баг баригдсан мал угаах ванн", " Хогийн менежмент, ажлын хөлс, ЗД-н дэд хөтөлбөр, Ич гүрэнд тоног төхөөрөмж, материалын үнэ" зэрэг ажлууд нь хүлээн авсан акт, ажлын тайлангүй, анхан шатны баримт бүрдэлгүй	1	118,200.0					1	118,200.0		
	Малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлсэн "Өвс тэжээл", "Тохижилт", "Малын эрүүл мэнд хамгаалах", "Малын сэг зэм устгах", "Намарзан багийн халдваржуулалт" зэрэг ажлуудын анхан шатны	1	38,157.2			1	38,157.2				

	баримт, ажлын тайлан, хүлээн авсан акт байхгүй, юу хийсэн нь тодорхойгүй зардал гарсан зөрчил байна									
	Өөлд түмний наран хийморь" баримтат кино, "Ургын бичигтэй өөлд түмний удам соёлыг сурталчлах өдөрлөг баяр наадам, баримтат кино санхүүжүүлсэн. "Тохижилт" нэрээр урсгал зардал, жишиг хашаа санхүүжүүлсэн байна.	1	50,856.5			1	50,856.5			
	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажил "Чулуун арслан" хийлгэж, хөшөө дурсгал санхүүжүүлсэн.	1	4,000.0	1	4,000.0					
Хоршоо хөгжүүлэх сан	Тайлан дээр байгууллагаас авах авлагаар бүртгэгдсэн он дамжсан зээлийн үлдэгдэл нь 13.8 сая төгрөгийн зээн холбогдогч байхгүй, барьцаалбар үүсгээгүй, зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй, 2011-2019 онуудад олгогдсон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулаагүй зөрчил байна	1	13,779.0				1	13,779.0		
		5	224,992.7	1	4,000.0	2	89,013.7	2	131,979.0	

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР : Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: Д.ЭНХЖАРГАЛ

